БУЛГАН АЙМГИЙН УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

Төлөвлөгөөний биелэлтийг хянасан: Төсвийн Төвлөрүүлэн захирагч

ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ ............ /Л.ОЮУНЖАРГАЛ/

2025.12.17
(огноо)

Төлөвлөгөөг тайлганасан: Төсвийн Шууд захирагч

БУЛГАН АЙМГИЙН УС ЦАГ УУР,ОРЧНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ МҮХ-ИЙН ДАРГА ............ / Б.НАНДИНБАТ /

2024.12.05
(огноо)

**БУЛГАН АЙМГИЙН УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН**
**2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэл хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| **НЭГ.Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт** | | | | | | | |
| Стратеги төлөвлөгөөний зорилт 1. УС ЦАГ УУР, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ УЛСЫН СҮЛЖЭЭНИЙ ТАСРАЛТГҮЙ, ТОГТВОРТОЙ АЖИЛЛАГААГ ХАНГАХ | | | | | | | |
| 1 | Ус цаг уур, байгаль орчны хяналт шинжилгээний улсын сүлжээний үйл ажиллагааг тасралтгүй явуулах, техник технологийн шинэчлэл хийх | Улсын төсөв | Гүйцэтгэлийн хувиар | 99,3 | 100 | Ус цаг уур, байгаль орчны хяналт шинжилгээний улсын сүлжээний үйл ажиллагаа тасралтгүй технологийн дагуу хийгдэж, автомат станцын хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна. | 99,9 |
| 1.1 | Цаг уурын шинжилгээний өртөө, харуулуудад уур амьсгалын шинжилгээний ажлыг хөтөлбөрийн дагуу чанартай бүрэн хийж гүйцэтгэх | Улсын төсөв | Ажлын үзүүлэлт, хувиар | 99.2% | 99.5% | Тайлангийн хугацаанд ус цаг уурын өртөө, харуулууд хөтөлбөрт ажлыг бүрэн хийж төлөвлөгөөний биелэлт-100%, ажиглалтын чанар-99,2%, тайлангийн ирц-100%, мэдээний чанар 99.7% явцтай байна. Дундаж дүн 99.5%-тай ажиллаж өмнөх оны мөн үеэс 0.3%-н ахицтай ажилласан байна. Шүүмжийн чанар 99,7%тай байна. | 100 |
| 1.2 | Хөдөө аж ахуйн цаг уурын шинжилгээний ажлыг хөтөлбөрийн дагуу чанартай хийж гүйцэтгэх. | Улсын төсөв | Ажлын үзүүлэлт хувиар | 100% | 100% | Хөдөө аж ахуйн цаг уурын ажиглалт судалгааны ажлуудын хөтөлбөрийн дагуу бүрэн хийгдэж, а/ч-100%<br>Хөрсний чийгийн байнгын ажиглалтыг 2 өртөөний 2 талбайд Булган өртөөнд 3-6 сар, Ингэттолгой өртөөнд 4-6 саруудад хийж, ажлын гүйцэтгэл 100%, хөтөлбөрийн биелэлт-100, ажиглалтын чанар-100.<br>Хөрсний чийгийн явуул судалгааг 4 сард Бүрэгхангай, Хутаг, Тэшиг, Сэлэнгэ сумдад хийлээ. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Ингэттолгой өртөөнд буудайн ажиглалтыг 5-р сараас хийж эхэлсэн. Бэлчээрийн хортон шавьж, мэрэгчдийн гаралт, тархалт өсөлт, хөнөөл учруулалтыг тооцох орчин зүйн ажиглалтыг 4-6-р саруудад хөтөлбөрийн дагуу хийсэн. Мал аж ахуйн цаг уурын хонь, ямаа, үхрийн харуулд шинжилгээний ажлын хөтөлбөрийн биелэлтийг хангаж цаг уурын болон малын аж ахуйн цаг уурын ажиглалт судалгаа бүрэн хийгдэж байна. Хөтөлбөрийн биелэлт-100, | |
| 1.3 | Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд агаар хөрс гадаргын усны чанарын хяналт, орчны цацрагийн хяналт шинжилгээний ажлыг хийж гүйцэтгэх | Улсын төсөв | Ажлын үзүүлэлт хувиар | 99.89% | 99.9% | Булган сумын агаарын бохирдолыг 2024 оны жилийн эцсийн байдлаар Агаар дахь хүхэрлэг хий болон азотын давхар ислийн хэмжилт, шинжилгээг хийж тус бүр 584 удаа агаарын өдөр тутмын шинжилгээнд хэрэглэгддэг уусмал урвалж болох SO2, NO2-ийн гуурс дэвтээгчийг 10 удаа, бүх урвалжуудыг шинэчлэн SO2-ийн калибровкийг-12.88 болон 12.35 коэффицентээр, NO2-ийн калибровкийг-8.79 болон 7.93 коэффицентээр тус тус тогтоож инженер техникч нарт хүлээлгэн өгч, Эрэн-Тэшиг, Харгал-Тэшиг тус бүр 4, Эг-Хантай, Орхон-Сайхан усны харуулуудаас тус бүр 5, Зүүнтүрүү-Булган 6, Сэлэнгэ-Хялганат 7 дээж авч гадаргын усны дээжинд 18 үзүүлэлтээр усны химийн найрлага шинж чанарыг усны чанарын MNS 4586:1998 стандарттай харьцуулан тодорхойлоход бохирдол хэвийн стандарт хэмжээнээс давж | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бохирдсон үзүүлэлтгүй байсан мөн, “Булган Мээж” ХХК-ний ТЦ байгууламжийн орох гарах хэсгээс 10удаагийн давталтаар 20 дээж авч 10 үзүүлэлтээр хаягдал бохир усны MNS 4943:2015 стандартын дагуу шинжлэхэд хаягдал усан дахь нийт азотын агууламж 2,8-4,7 дахин фосфорын агууламж-1,1-2,6 дахин ПИЧ 1,2-3,1 дахин их бохирдолтой, цэвэршилтийн хэмжээ 25-50% тай байлаа. | |
| 1.4 | Ус судлалын харуулуудад шинжилгээний ажлыг хөтөлбөрийн дагуу чанартай хийж гүйцэтгэх, урсац бодох | Улсын төсөв | Ажлын үзүүлэлт хувиар | 98.3 | 98.5 | Ус судлалын 12 харуулд шинжилгээний хөтөлбөрт ажлууд технологийн дагуу бүрэн хийгдэж ажиглалтын чанар 100.0 %, Шүүмж дүн 96,9% дундаж дүн 0,20 өссөн байна. Түвшин 2520 хэмжихээс 2520 түвшин хэмжсэн. Харуулууд нийт 224 өнгөрөлт хэмжсэн байна. | 99,5 |
| 1.5 | Ус судлалын 2 харуулд мэдээлэл нь нээлттэй харагддаг усны түвшин хэмжих автомат багаж суурилуулах; | Улсын төсөв | Автомат түвшин хэмжигч багаж суурилуулсан харуулын тоо; | 0 | 2 | Төвөөс хуваарилагдаж ирээгүй байна. | 0 |
| 1.6 | Цаг уурын автомат станц 1 ширхэгийг худалдан авч суурилуулах; | Улсын төсөв | Автомат станцаар хангагдсан өртөө, харуулын тоо; | 18 | 19 | Автомат станцын хэвийн ажиллагаа хангагдсан. 2 автомат станц оны сүүлээр хуваарилагдаж ирсэн боловч зарим дагалдах хэрэгсэл ирээгүй тул хүлээгдэж байна. | 100 |
| 1.7 | Шинэ технологи нэвтрүүлэх, автомат станцын тасралтгүй ажиллагааг хангах, багаж тоног төхөөрөмжийн хангалт, засвар үйлчилгээ, баталгаажуулалт хийх | Улсын төсөв | Тоо | 20 | 24 | Сэлэнгэ өртөөний CAMS-620 автомат станцад засвар үйлчилгээ хийж хэвийн ажиллуулж байна. Хутаг-Өндөр өртөөний MD-801 автомат станцын логер гэмтэж ажиллахгүй болсон тул шинээр солих захиалга газарт өгсөн. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Харуулуудын JDL-790 автомат станцын логерт тохиргоо хийж хэвийн горимд оруулсан. БОХЗТЛ-т шалгалтын багажууд болон Гурванбулаг өртөөний анериод барометрт шалгалт тохируулга хийлгэсэн. БОАЖСайдын хөрөнгө оруулалтаар хүчин чадал сайтай PC, нотевоокээр төвийн инженер техникч нар, орон нутгийн өртөө, харуулыг бүрэн хангаж МҮХ I9 комьпютер, УЦУОШТөвд ухаалаг самбар худалдан авалт хийгдлээ. | |
| 1.8 | Салбаруудыг мэргэжил аргазүйн удирдлагаар хангах технологийн хяналт тавих | Улсын төсөв | Шалган туслах ажлын төлөвлөгөөний биелэлт, хувиар | Шалган туслах ажлын төлөвлөгө ө -74% | 90 | Булган, Сайхан, Орхон-Сайхан, Зүүнтүргү-Булган, Ачуут-Булган харуулуудад болон бүх сумдад шалган туслах ажил хийгдсэн. Тус салбаруудад гэнэтийн шалгалт, өртөө, харуулын дотоод ажилтай танилцаж шинжилгээний талбайн зохион байгуулалт, ажиглагч, техникч нараас түвшин тогтоох шалгалт авах, бэлчээрийн төлөв байдлын ажиглалтын сургалт дадлага хийх зэрэг ажлууд хийгдлээ. Өртөө харуулын тайланд техник болон орон зайн шүүмж шалгалт хийж хариу зааварчлагыг тухай бүр нь салбаруудад хүргүүлж хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан. МААЦУ-н үхэр, хонь, ямааны харуулд шалган туслах ажил хийгдэж AWS-н мэдээ хурааж, тайлан материалыг шалгаж хариу зааварчилгаа хүргүүлэх ажлууд хийгдэв. 100 жилийн тэмдэглэн өнгөрүүлэх болон өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэнтэй | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | холбогдуулан шалган туслах ажлууд эхний хагас жилд бүрэн хийгдээгүй байна.Сүүлийн хагаст бүх салбарт шалган туслах ажил хийгдэж заавар зөвлөмж өгч ажиллалаа. Мөн ЦУОШГ –аар ахлуулсан баг манай төв болон сумдаар ажиллаж ажил байдалтай танилцаж зөвлөмж өгсөн байна. Агаар усны хяналт шинжилгээ хийх, инженерын ажилд шалган туслах ажлыг 2 удаа хийж, алдаа дутагдалыг засах заавар зааварчилгаа өгч ажиллаа. | |
| **ХОЁР. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт** | | | | | | | |
| Стратеги төлөвлөгөөний зорилт 2. УС ЦАГ УУРЫН МЭДЭЭ, МЭДЭЭЛЛЭЭР НИЙГМИЙН ХЭРЭГЦЭЭГ ТАСРАЛТГҮЙ ШУУРХАЙ ХАНГАХ | | | | | | | |
| 2 | Ус, цаг уур, орчны төлөв байдлын болон урьдчилсан мэдээллээр орон нутгийн хэрэгцээг хангах ажлыг зохион байгуулах | Улсын төсөв | Гүйцэтгэлийн хувиар | 98% | 100% | Ус, цаг уур, орчны төлөв байдлын болон урьдчилсан мэдээллээр орон нутгийн хэрэгцээг хангах ажлыг зохион байгуулан ажилласан. | 99,9 |
| 2.1 | Цаг уурын 6 өртөө, 10 харуул, ус судлалын харуулуудын мэдээг олон улсын болон бүсийн солилцоонд хяналтын хугацаанд бүрэн дамжуулах, байгууллагын сүлжээ ашиглалтын хэвийн ажиллагаа аюулгүй байдлыг хангах | Улсын төсөв | Сүлжээ ашиглалт, мэдээ дамжуулалтын дүн, % | 100% | 100% | Цаг уурын 6 өртөөний 17568, 10 харуулын 10980 мэдээг улс орон нутгийн мэдээлэл солилцоонд 100 % оруулсан. Агаарын бохирдлын мэдээг сард 3 удаа нийт 36 удаа, усны бохирдлын мэдээг 12 удаа, хөрсний бохирдлын мэдээг 1 удаа дамжуулсан. Сүлжээ ашиглалт, тоног төхөөрөмжийн бэлэн байдал хангагдсан. 2023 онтой харьцуулахад мэдээний дахин дамжуулалт болон хоцролт дараах байдлаар өссөн буюу буурсан байна. Могод өртөө 11-ээр, харуулаас Хангал 10-аар, Рашаант 5-аар, Сайхан 6-аар нэмэгдсэн байна. Бусад өртөө харуулуудын мэдээний | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дахин дамжуулалт буурсан үзүүлэлттэй байна. | |
| 2.2 | Цаг агаарын урьдчилсан мэдээг цаг хугацаанд нь чанартай гаргаж үйлчлэх | Улсын төсөв | НМ+ХМ+5ХМ= дундаж таарц, % | НМ 95.7%, 1ХМ 94.5%, 5ХМ 88.9% дундаж таарц=93.0 % | НМ 95.8%, 1ХМ 94.6%, 5ХМ 88.9% дундаж таарц=93.1% | -Нарийвчилсан урьдчилсан мэдээний таарц-96,3%, 1 хоногийн урьдчилсан мэдээний таарц-94,3%, 5 хоногийн урьдчилсан мэдээний таарц-90,4%-тай тус тус зохиож дундаж таарц 93,7% байна. Суурь түвшнээсээ 0,7%-иар ахиулж ажиллаа.<br>-Холбогдсон иргэд, ААН-д хүссэн цаг агаарын мэдээ, мэдээллээр зөвлөмж өгч үйлчилж ажилласан. | 100 |
| 2.3 | Цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс эртнээс сэрэмжлүүлэх | Улсын төсөв | АҮ, ГҮ-ийн СМ, УСМ-ний Таарц+Онч+Урьдчилан илрүүлэлт=дундаж таарц, % | Таарц 88.2%, онч 96.2%, урьдчилан илрүүлэлт 100%, дундаж таарц=94.8% | Таарц 88.3%, онч 96.3%, урьдчилан илрүүлэлт 100%, дундаж таарц=94.9% | Сэрэмжлүүлэг мэдээний таарц 90,0%, онч 92,7%, илрүүлсэн байдал 100%-тай зохиож дундаж таарц 94,2%-тай байна. Суурь түвшнээсээ 0,6%-иар буурсанч цаг агаарын гаралтай аюултай болон гамшигт үзэгдлээс эртнээс сэрэмжлүүлэх үүргээ цаг тухайнд нь биелүүлж ажилласан. 6 сард их бороогоор, 9 сард цочир хүйтрэлтээр сэрэмжлүүлэг мэдээ зарласан боловч Урьдчилан сэргийлэх мэдээний хэмжээнд хүрч таарц, онч буурсан байна. | 99,4 |
| 2.4 | Нислэгийг мэдээгээр үйлчилж нислэгийн аюулгүй байдлыг хангасан байх | Улсын төсөв | Шуурхай үйлчилгээ, зохицуулалт, мэдээ зохиолтын чанар, УМ-ний таарц =дундаж дүн, % | Шуурхай үйлчилгээ 100%, Шуурхай зохицуулалт 100%, мэдээ | Шуурхай үйлчилгээ 100%, Шуурхай зохицуулалт 100%, мэдээ зохиолтын чанар 99.4%, УМ-ний | Шуурхай үйлчилгээ 100%, Шуурхай зохицуулалт 100%, мэдээ зохиолтын чанар 92,8%, УМ-ний таарц 96,1%, дундаж дүн 98,6% байна. Нислэгийг цаг агаарын мэдээ, мэдээллээр ханган үйлчлэх ажлыг 98,6%-тай хийж суурь | 99,7 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | зохиолтын чанар 99.3%, УМ-ний таарц 95.9%-дундаж дүн=98.8 | таарц 96.0%-дундаж дүн=98.9 | түвшнээсээ 0,2%-иар буурсан. Зуны саруудад мэдээ зохиолтонд санамсаргүй шивэлтийн алдаа их гаргасантай холбоотойгоор нийт дундаж дүнг доош нь татсан байна. | |
| 2.5 | Цаг агаарын УРЬДЧИЛАН СЭРЭМЖЛҮҮЛЭХ систем буюу http://alarm.tsag-agaar.gov.mn/ сайтанд мэдээг цаг хугацаанд нь оруулах | Улсын төсөв | Нөхцөл бүрдсэн үед оруулсан мэдээний төрөл (тоо) | Нөхцөл бүрдсэн үед анхааруулга мэдээ 478 удаа, сэрэмжлүүлэг мэдээ 390 удаа урьдчилан сэргийлэх мэдээ 22 удаа оруулсан | Анхааруулга, сэрэмжлүүлэг, урьдчилан сэргийлэх мэдээ 890 | Нөхцөл бүрдсэн үед анхааруулга мэдээ 183 удаа, сэрэмжлүүлэг мэдээ 83 удаа оруулж ажилласан байна. 7 сараас хойш http://alarm.tsag-agaar.gov.mn/ сайтанд орон нутгаас хандах эрхгүй болсон тул мэдээллийг бусад сувгаар түгээсэн. | 100 |
| 2.6 | Хэрэглэгчдэд 7 хоногийн урьдчилсан төлөв, цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс анхааруулах, сэрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх мэдээг “БАГЦ МЕССЕЖ” үйлчилгээгээр хүргэх | Улсын төсөв | Хэрэглэгчдийн тоо | 66 байгууллага 308067 иргэнд үйлчилсэн | 66 байгууллага 308067-аас доошгүй иргэдэд үйлчилсэн байна. | 7 хоногийн цаг агаарын урьдчилсан төлөвийг 52 удаа, аюултай болон гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх АНХААРУУЛГА МЭДЭЭ 36, СЭРЭМЖЛҮҮЛЭГ МЭДЭЭ 12 удаа 72-12 цагийн өмнөөс гаргаж цаг тухайд нь багц мессежээр давхардсан тоогоор 66 байгууллага, 324652 иргэнд өгч үйлчилсэн байна. Хишиг-Өндөр 1, 2, 9 сард, Сэлэнгэ, Рашаант 1 сард, Баян-Агт 3, 9 сард, Орхон 4, 6-11 сард, Сайхан 9-11 сард сунгалт хийгдээгүй байна. Дээрх сумдууд масс мессежээ ашиглаагүй үед олон нийтийн | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сүлжээг сайн ашиглаж мэдээ мэдээллийг цаг тухайд нь шуурхай дамжуулж байлаа. | |
| 2.7 | Хавар, намрын улиралд хуурайшлын зэргийг тогтоож, түймрээс анхааруулсан байх. Шаардлагатай үед хугацаа сунгаж түймрийн эрсдэлийг үнэлэх | Улсын төсөв | Аймаг, сумын түвшинд хуурайшилтын зэргийг тогтоосон тоо | 168 | 168 | Хавар 3 сарын 20-ноос 6 сарын 20, намар 8 сарын 20-ноос 11 сарын 20-ныг дуустал хуурайшлын зэргийг өдөр бүр бодож тусгай хамгаалалтын газрууд, сумдын байгаль хамгаалагчид, аймгийн онцгой байдлыг газарт 186 удаа, 3, 4-р зэрэг хүрсэн үед “Булган аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв” фэйсбүүк хуудсанд анхааруулга мэдээ бичиж үйлчилж байна. | 100 |
| 2.8 | Цаг агаарын төрөл бүрийн урьдчилсан болон тойм мэдээгээр үйлчлэх, хүссэн мэдээллээ авах боломжийг бүрдүүлж ажиллах | Улсын төсөв | Өдөр бүр [www.bulgan.tsag-agaar.mn](www.bulgan.tsag-agaar.mn) сайтанд болон “Булган аймгийн ус цаг уур орчны шинжилгээний төв” фэйсбүүк хуудсанд мэдээг шинэчлэн тавьсан мэдээний тоо | Цахим сайтад мэдээллийн 60% шинэчлэг дэж байсан | Цаг агаарын бүх төрлийн мэдээ мэдээллийг цаг тухайд нь 100% шинэчлэн [www.bulgan.tsag-agaar.mn](www.bulgan.tsag-agaar.mn) болон “Булган аймгийн ус цаг уур орчны шинжилгээний төв” фэйсбүүк хуудас, байгууллагын самбар дээр тавьж үйлчлэх. | Хагас хоног болон 1-5 хоногийн урьдчилсан мэдээ тус бүр 365, 7 хоногийн урьдчилсан мэдээ 52, анхааруулга мэдээ 36, сэрэмжлүүлэг мэдээ 12, сар, улирлын урьдчилсан төлөв 12, өнгөрсөн хоногийн тойм 365, 7 хоногийн тойм 52 удаа, агаарын бохирдолын мэдээг 15 удаа, усны бохирдолын мэдээг 3 удаа 10 хоногийн тойм 18 удаа, өвөлжилт, хаваржилт, зуншлагын тойм мэдээг тус тус гаргаж www.bulgan.tsag-agaar.mn сайтанд болон “Булган аймгийн ус цаг уур орчны шинжилгээний төв” фэйсбүүк хуудсанд шинэчлэн тавихаас гадна аймаг, сумын удирдлагуудад өгч үйлчилсэн. Одоогоор тус хуудас нь 4800 орчим байнгын дагагчтай болсон цаашид хэрэглэгчдийнхээ тоог нэмэн | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөгжүүлэн ажиллана. Сард дунджаар 35000-40000 хэрэглэгч тогтмол манай хуудаснаас мэдээ мэдээллээ авч ажил аж ахуйдаа хэрэглэж байна. Мөн утсаар холбогдсон иргэд, ААН-д хүссэн цаг агаарын мэдээ, мэдээллээр зөвлөмж өгч үйлчилж ажиллаа. ХААЦУ-ын инженер Э.Сарантуяа ХААЦУСХ-н дарга Ц.Бат-Оюун, МААЦУ-н инженер Г.Раднаа нартай хамтран УЦУОСМХ-н Эрдэм шинжилгээний бүтээлд нийтлэл оруулсан. | |
| 2.9 | Байгаль цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн судалгаа, бүртгэл хийх | Улсын төсөв | Байгаль цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн бүртгэгдсэн тоо, хохирлын хэмжээ | 2023 онд нийт 84 удаа аюулт, 4 удаагийн гамшигт үзэгдэл ажиглагд аж нийт 566,921,000 төгрөгний хохирол учирсан байна. | Аймгийн нутаг дэвсгэрт ажиглагдсан аюултай болон гамшигт үзэгдлийн бүртгэл, хохирлын судалгаа хийгдсэн байна. | 2024 онд Булган аймгийн нутгаар аюултай үзэгдэл 59 удаа, гамшигт үзэгдэл 9 удаа ажиглагдсан байна. Үүнээс:<br>**Аюултай үзэгдэл:**<br>**1.** 6 сарын 10-нд Сэлэнгэ суманд ажиглагдсан хүчтэй нөөлөг салхи, ширүүн аадар борооны улмаас ЕБС, Спорт заал, Дотуур байр, ЭМТ-ийн дээвэр хэсэгчлэн хуурсан. Ингэттолгой өртөөний Хурын хувингийн шон унасан.151 айл өрхийн хашаа, 1 айлын 5 ханатай гэр нурж, цахилгааны 7 тулгуур шон унасан.<br>**Гамшигт үзэгдэл:**<br>**1.** 2023-2024 оны өвлийн зуднаар адуу 66490, үхэр 53566, тэмээ 118, хонь 743420, ямаа 277270 нийт 1140864 толгой мал хорогдсон байна.<br>**2.** 6 сарын 24-нөөс 25-нд шилжих шөнө Булган суманд орсон аадар борооны улмаас уруйн үер бууж Зүүн түрүүний голын улсын чанартай авто гүүр нурж унасан. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | **3.** 7 сарын 11-нд Сайхан сумын төв, Баян-Агт сумын Хануйн рашааны ойролцоо уруйн үер бууж Баян-Агтад 10 кВт-ын 2 шон унасан, 3 газар шилэн кабелийн утас ил гарч 2 газраар тасарч сүлжээ тасарсан, Хануй голын ай савд байсан 2 суудлын авто машин урссан, Булаг хашсан 3 хашаа эвдэрч урссан, Цагаа голын төмөр гүүр гулзайж гүүрний 2 талаар эргэ үүссэн. Сайхан суманд 1 автомашин урссан байна. Мөн энэ өдөр Могод, Сайхан суманд аянга бууж Сайханд 7 үхэр аянгад ниргүүлж үхсэн. Могод сумын цаг уурын өртөөний Логер, компьютер 2, конвертр, камер зэрэг тоног төхөөрөмжүүд шатсан байна.<br>**4.** 7 дугаар сарын 21-ний өдөр Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын Үүрийн гол орчим 60 мм тунадас орж 22-ны өглөөний 08 цагийн мэдээгээр Үүрийн голын усны түвшин 293см-р нэмж үер болсон байна. Энэ үер манай аймагт 23-24-ний өдөр шилжин ирж мөн Тэшиг сумын нутгаар 21, 22-нд үргэлжилсэн бороо 37 мм орсон. Үүний улмаас усны түвшин 162см-р нэмэгдэж Эгийн голын гүүрийг даван үерийн аюултай түвшинд хүрч далан сэтэрч ус хэмждэг багаж тоног төхөөрөмжийг усанд урсгасан байна.<br>**5.** 7 сарын 29-нд Булган суманд аянга бууж Монголын цахилгаан холооны Булган аймаг дахь салбарын тоног төхөөрөмж, айлуудын цахилгаан хэрэгсэл шатсан байна. | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.10 | Цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн урьдчилсан мэдээний хүртээмжийн нарийвчилсан судалгаа хийх; | Улсын төсөв | Судалгааны үр дүнгээр тайлан гаргах; | 0 | Судалгааны мэдээлэл цуглуулсан байх Асуулга явуулж дүгнэлт, үр дүнг гаргасан байх. | Булган нисэх буудлын 9 албан хаагчид болон 5 сарын 10-нд болсон Нээлттэй хаалганы өдөрлөгөөр санал асуулга хэрэглэгчдийн дунд явууллаа. Энэхүү судалгаанд 10 асуулгын хүрээнд 80 хэрэглэгч хамрагдсан байна. Цаг агаарын аюултай болон гамшиг үзэгдлийн урьдчилсан мэдээний таарц сайн байгаа хэдий ч хүртээмж муу байна. Тус төвөөс гаргаж байгаа мэдээг интернэт орчноос хол хүмүүс хэрэглэдэггүй байна. Цаг агаарын урьдчилсан мэдээг хэрэглэх хүсэлтэй хүн бүрт хүрч үйлчлэх шаардлагатай. | 100 |
| 2.11 | Тусгай хэрэгцээний урьдчилсан болон бодит мэдээгээр байгууллага, аж ахуйн нэгж, ард иргэдийн шаардлагад нийцүүлэн үйлчлэх | Улсын төсөв | Тусгай хэрэгцээний мэдээг тухай бүрт хугацаанд нь чанартай гаргаж үйлчилсэн тоо | 74 | 74 | Гэрээт байгууллагуудад цаг агаарын түүвэр, тодорхойлолт, урьдчилсан мэдээг 10 удаа, аймаг, сумын тамгын газар, ОБГ, АЦГ, ГХБХБГ-т болон ард иргэд, ААН-д цаг агаарын түүвэр, тодорхойлолтыг давхардсан тоогоор 25 удаа гаргаж үйлчилсэн байна. | 100 |
| 2.12 | Байгууллагын архив, мэдээллийн дэд санд баяжилт хийх | Улсын төсөв | Гүйцэтгэлийн хувиар | 100% | 100% | 2024. I-IV сарын 2055 файл, 156.56mb мэдээ хүлээн авч шалган, тасалдлын протокол хөтлөж, актаар баталгаажуулан АМНС-д сүлжээгээр хүргэсэн. 2024 оны I-III сарын 144 файл, 8075kb мэдээг актаар тус тус хүлээн авсан. 2023 оны III-XI сарын 5.62 mb эх мэдээ актаар хүлээн авч санд оруулсан. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.13 | Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд намар бэлчээрийн даац багтаамж тодорхойлох, өвлийн цасны болон зудын эрсдэлийн зураглал хийж орон нутгийн удирдлага, иргэдэд үйлчлэх | Улсын төсөв | Гүйцэтгэлийн хувиар | 100% | 100% | 2023-2024 оны өвөл зудын эрсдэлийн зураглалыг 2, цасны зураглал 13 удаа гаргаж аймаг орон нутгийн удирдлага ард иргэдэд үйлчлэв. Өвлийн цасны хээрийн хэмжилтийг 16 сумын 84 цэгт хийж орон нутгийн удирдлага ард иргэдэд үйлчилсэн.<br>Өвөл хаврын бэлчээрийн даац багтаамж тодорхойлох ажил 8 сард бүрэн хийгдэж бичлэлт 100%. | 100 |
| 2.14 | Агаарын бохирдлын эх үүсвэрийн Улсын нэгдсэн тоо бүртгэлийг зохион байгуулах | Улсын төсөв | Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогын тайлан гаргах | 100% | 100% | АБЭҮ-ийн 2023 оны тооллогын ажлыг Булган аймгийн 16 сум 1 тосгоны хэмжээнд 2023 оны 12 сарын 01 наас 2024 оны 3 сарын 10-ний хооронд хийж гүйцэтгэлээ. Тооллогын дүнгээр: Булган аймгийн нийт 16057 утаа гаргадаг өрх тоологдож 3506 тн нүүрс, 82564 $м^3$ мод, 16537 тн бусад төрлийн түлш хэрэглэсэн байна. 2024 онд аймаг сумын төвийн ердийн галлагаатай айл өрхийн 3-15кВт хүртэл хүчин чадалтай зуух ашигладаг 7091 өрхийн зуух мэдээлэлийн санд шивэгдсэн. 2024 онд Усан халаалтын 15-100кВт хүртлэх хүчин чадалтай 23 зууханд 972 тонн нүүрс, 1044 метркуб мод, 100-4200кВт хүртлэх хүчин чадалтай 32 зууханд 19040 тонн нүүрс, мөн 4200кВт-аас дээш хүчин чадалтай 2 зууханд 18257 тонн нүүрс хэрэглэсэн. Булган аймгийн хэмжээнд нийт 57 зууханд 38269.3 тонн нүүрс,1044 м3 мод хэрэглэж өмнөх жилээс7494 тонн нүүрс, 39 м3 модоор түлшний хэрэглээ өссөн дүнтэй байна | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.15 | Аймгийн нутаг дэвсгэрт цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах | Улсын төсөв, Орон нутгийн төсөв | Үйл ажиллагааны үр дүнгийн хувиар | 100% | 100% | 2024 оны 5 дүгээр сарын 21-ний байдлаар Булган аймгийн нутаг дэвсгэрт цаг агаарт зориудаар нөлөөлөх хэрэгцээ шаардлага байгаа талаар үнэлгээ хийхэд 6.8 буюу /дунд/ гарсан нь ЦАЗН-х хэрэгцээ шаардлагатай байгааг харуулсан. 5 дугаар сард цаг агаарт зориудаар нөлөөлөх 3 удаагийн нөхцөл бүрдсэн боловч “Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам” ЦУОШГ-аас тушаал шийдвэр гараагүй, мөн манай аймгийн нутгаар хуурайшилтын зэрэг өндөр байсан боловч ой, хээрийн түймрийн гаралт бага, бэлчээрийн ургамлын ургалт хэвийн байсан тул ЦАЗН-х үйл ажиллагааг 5 дугаар сард явуулаагүй. 6 дугаар сарын 30-ны байдлаар цаг агаарт зориудаар нөлөөлөх хэрэгцээ шаардлага байгаа талаар үнэлгээ хийхэд 3.2 буюу цаг агаарт зориудаар нөлөөлөх хэрэгцээ шаардлагагүй байгааг харуулж байна. 6-8 дугаар сарууд хур бороо элбэг, усархаг бороо ихтэй байсан тул байгалийн жамаар нь оруулахаар экспедицийн бие бүрэлдэхүүн хуралдаж шийдэн хээрийн гаралтыг энэ жил зохион байгуулаагүй. Сар бүр багаж тоног төхөөрөмжид цэвэрлэгээ үйлчилгээ хийж бэлэн байдлыг хангаж ажилласан. Мөн борооны пуужинг түр агуулах байранд дүрэм журмын дагуу хадгалж байна. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.16 | Байгаль орчны шинжилгээний лабораторийг итгэмжлэлд давтан хамруулж, хэмжлийн үр дүнг сайжруулах | Улсын төсөв | Итгэмжлэлийн гэрчилгээ сунгах | - | Хэмжлийн үр дүн сайжирсан байна. | Байгаль орчны шинжилгээний лаборатори MNS ISO/IEC 17025:2018 стандарт шаардлагын дагуу итгэмжлэлд хамрагдаж Тус лаборатори нь төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны шугамд холбогдсон нь шинжилгээний ажил хэвийн явагдах нөхцөл бүрдэж хэмжлийн үр дүнд сайнаар нөлөөлж байна. Харилцагч байгууллага болох “Платиниум ланд ХХК”, “Си Эл энд Эс Эм ХХК” , “Хан тэнгэрийн дуудлага” ХХК, “Булган Мээж”, Өгөөж Баянхангай, Хульж ресорт, Сорогг Ланд Магнай трейд ШТС-ууд мөн Хос хас зэрэг ХХК –нуудын орчны хяналт шинжилгээний ажлыг газар дээр нь очиж дээж авч шинжилгээнд хамруулж жилийн турш байгууллагын дансанд нийт 9.388,800 төгрөгний орлого оруулсан. Дахин итгэмжлэл баримт бичгээ холбогдох байгууллагад хүргүүлсэн. | 100 |
| ГУРАВ. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт | | | | | | | |
| Стратеги төлөвлөгөөний зорилт 3. АЛБАН ХААГЧДЫН МАНЛАЙЛЛЫГ ХАНГАХ, АЖИЛЛАХ ОРЧИН НӨХЦЛИЙГ САЙЖРУУЛАХ, ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ | | | | | | | |
| 3 | Удирдлагын болон албан хаагчдын манлайллыг хангах, ажиллах орчин нөхцлийг сайжруулах, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх | Улсын төсөв | Албан хаагчдын манлайлал сайжирч, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлнэ | 100% | 100% | Удирдлагын болон албан хаагчдын манлайллыг хангаж, ажиллах орчин нөхцлийг сайжруулах, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэхэд анхааран ажилласан. | 100 |
| 3.1 | Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх | Улсын төсөв | Ёс зүйн зөрчил гаргасан албан хаагчтай хариуцлага тооцох, ХАСХОМ- | ХАСХОМ-ийг хугацаанд нь хүргүүлсэн | Гүйцэтгэл тоогоор | Ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сурталчилгааг зохион байгуулж, ХАСХОМ гаргах 4 албан хаагч мэдүүлгээ хугацаанд нь гаргаж | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ийг хугацаанд нь явуулсан байх | | | өгсөн. Байгууллагын Ёс зүйн дэд хороог байгуулж 2 удаагийн цахим сургалт зохион байгуулав. | |
| 3.2 | Албан хаагчдын ажиллах нөхцөл, хөдөлмөр, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр төлөвлөгөөг хэрэгжүүлэх | Улсын төсөв | хөтөлбөр төлөвлөгөөний биелэлтийг хувиар тооцсон байх | 90% | Хэрэгжилт хувиар | | 100 |
| 3.3 | Байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх | Улсын төсөв | Сургалтын төлөвлөгөөний биелэлтийг хувиар тооцсон байх | 2023 оны сургалт % биелэлттэй. | Хэрэгжилт хувиар | Хүний нөөцийг чадавхжуулах сургалтын хөтөлбөр төлөвлөгөө гарган ажиллаж биелэлт 100%-тай байна. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний өөрчлөлт, Аюул агаар мэдээ, Газар хөдлөлтийн тухай хичээл сургалтад<br>БНСУ-д агаарын чанарын хяналт шинжилгээ, мэдээлэл агаарын бохирдолыг бууруулж буй арга хэмжээ, шинэ техник технологийн шинэчлэлийн талаархи сургалтанд 2024 оны 02 сарын 18-25 ний хооронд БОШЛ-ын хамрагдаж мэдлэг мэргэжлээ дээшлүүлэн ирсэн.<br>Уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох төлөвлөлтийн процессыг боловсронгуй болгох чадавхийг бэхжүүлэх НАП төслөөс зохион байгуулсан сургалтанд нийт албан хаагчид бүрэн хамрагдсан.<br>2024.05.24 УЦУОСМХ-ээс зохион байгуулсан УАӨ-н МАА-н салбарт үзүүлж буй нөлөөллийг зоо цаг уурын мэдээлэлд тулгуурлан шинжлэх сэдэвт сургалтыг зохион байгуулж оролцов.<br>Цахимаар бичиг баримт дамжуулах, цахим орчинд кибер аюулгүй хамгаалалт, Төрийн албан хаагчийн ёс зүй, Төрийн | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | албан хаагчийн ёс зүйн манайллыг дэмжих,ёс зүйтэй төрийн албыг бэхжүүлэх, БОШЛ-ын инженер техникч нар Грийн химистри ХХК-аас зохион байгуулсан “Усны шинжилгээ хийхэд тохиромжтой арга аргачлал” сэдэвт онлайн сургалтанд хамрагдсан. | |
| 3.4 | Албан хаагчдын “Гүйцэтгэлийн тайлан ” болон ажлын гүйцэтгэл үр дүн мэргэжлийн түвшинг үнэлэх журмаар дүгнэх | Улсын төсөв | Үнэлгээний хувь | Албан хаагчид дундажаар 80%-с дээш дүгнэгдсэн | харгалзан бодитой дүгнэж, арга хэмжээ авсан байх | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг хугацаанд нь гаргаж, аймгийн ЗДТГ, ЦУОШГ-т хүргүүлж ажиллалаа. Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн биелэлт, сургалт болон нийгмийн баталгааны тайлан гаргаж холбогдох газарт хүргүүлэн ажиллаа. Ажиллагсдын төлөвлөгөөний биелэлтийг дүгнэхдээ ажлын үзүүлэлт, үйлчилгээний чанарыг харгалзан дүгнэдэг болсон. | 100 |
| 3.5 | Байгууллагын хэмжээнд бүтээмж чанарыг сайжруулах төлөвлөгөө хэрэгжүүлэн ажиллах | Улсын төсөв | Төлөвлөгөөний биелэлт 85-аас дээш хувиар хэрэгжсэн байна. | Байгууллагын үйл ажиллагаа стандарт бүрэн хангагдаагүй, тэдний үйл ажиллагаанд өгч байгаа иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, хангалттай сайн байна. | Байгууллагуудын аливаа үйл ажиллагаанд стандарт хангагдсан байх, иргэд олон нийтийн сэтгэл ханамж тодорхой дээшилсэн байх | - Сургалтын төлөвлөгөөний дагуу НЦУТ-өөс танхим болон цахимаар зохион байгуулсан мэргэжил мэдлэг, ур чадварийг сайжруулах давтан сургал танд 1 техникч, 1 инженер хамрагдлаа.<br>- Монгол улсад Ус цаг уурын алба үүсэж хөгжсөний 100 жилийн ойн арга хэмжээг 5 дугаар сард зохион байгуулж салбарын албан хаагчдын дунд эрдэм шинжилгээний бага хурлыг хийлээ.<br>- Аймаг орон нутаг болон бусад байгууллагаас зохион байгуулах сургалтад 1-3 хүн хамрагдаж мэдлэгийн хүрээгээ тэллээ.<br>- Мөн өөрийн байгууллага дээр ОБГ-ын дэслэгч Батчимэгээс газар хөдлөлтийн аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, авч | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэрэгжүүлэх ажиллагааны талаар, ХХҮГ-ын мэргэжилтэн Энхмаагаас “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” сэдэвт хичээл танхим болон цахим хэлбэрээр авав. | |
| 3.6 | Байгууллагын ажилтан албан хаагчдын үндэсний бичиг, гадаад хэлний мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээг зохион байгуулах | Улсын төсөв | Албан хаагчдын мэдлэг чадвар дээшилсэн байх | Үндэсний бичгийн чадвар 50.0 хувьтай байсан. | Албан хаагчдын мэдлэг чадварыг урд оны мөн үеэс 15.0 хувиар дээшлүүлсэн байна. | Мэдпэг дээшлүүлэх, чадавхжуулах сургалтанд хамрагдаж мэдлэг чадвараа дээшлүүлж байна. | 100 |
| 3.7 | Байгууллагын ажилтан албан хаагчдад хууль эрх зүйн чиглэлээр сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах | Улсын төсөв | Албан хаагчдын хууль эрх зүйн мэдлэг чадвар дээшилсэн байх | Албан хаагчдын хууль эрх зүйн мэдлэг чадвар ... хувьтай байсан. | Албан хаагчдын хууль эрх зүйн мэдлэг дээшилсэн байх | Албан хаагчдын хууль эрх зүйн мэдлэг дээшүүлэх чиглэлд анхаарч сургалт нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж ажиллаа. 100, 98 дугаар тушаалын журмын өөрчлөлтөөр албан хаагчдад сургалт явуулав. Хөдөлмөрийн хууль болон бусад хуулийг судалж ажил амьдралд мөрдөн ажиллаж байна. | 100 |
| 3.8 | Албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношлогоонд бүрэн хамруулах арга хэмжээг хэрэгжүүлэх | Улсын төсөв | Төрийн албан хаагчдыг үзлэгт бүрэн хамруулж, эмчлэн эрүүлжүүлсэн байна. | Төрийн албан хаагчдын 30.0 хувийг хамруулсан. | Төрийн албан хаагчдыг 70.0 хувь хамруулж, эмчилэн, эрүүлжүүлсэн байна. | Энэ онд аймгийн хэмжээнд зохион байгуулж буй урьдчилан илрүүлэг шинжилгээнд албан хаагчдаа бүрэн хамруулах, 7 хоног бүр 2 цагийг идэвхтэй хөдөлгөөнөөр өнгөрөөх зорилгоор заал авч идэвхтэй хөдөлгөөнөөр эрүүл мэнддээ анхаарч байна. | 100 |
| 3.9 | Эрүүл, идэвхитэй амьдрал бүх нийтийн дасгал, хөдөлгөөнийг зохион байгуулах | Улсын төсөв | Албан хаагчдыг бүрэн хамруулсан байх | Эрүүл идэвхитэй амьдрал бүх нийтийн дасгал, хөдөлгөөний арга хэмжээнд албан хаагчидын 70 хувь | Албан хаагчдыг бүрэн хамруулж, хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлж, ажлын байрны дасгал хөдөлгөөнийг байгууллага бүр хийж хэвшсэн байх | Аймаг орон нутаг, улсын уралдаан тэмцээнд баг тамирчид зохион байгуулалттай оролцож идэвхтэй хөдөлгөөнөөр эрүүл мэнддээ анхаарч байна. Мөн “Цаг гаргая” аянд нэгдэн Бунхан толгойруу алхалт хийж байна. 7 хоногт 1 удаа 2 цагийг нийт ажилчид спорт зааланд бие бялдарыг сайжруулах арга хэмжээг зохион байгуулж байна. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хамрагдсан. | | | |
| 3.10 | Байгууллагын хүний нөөцийн асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх, анхан болон мэргэшүүлэх сургалтад хамруулах | Улсын төсөв | Байгууллагуудын ажилтан нар 100 хувь мэргэшсэн байх | 4 ажилтныг мэргэшүүлэх сургалтад хамруулсан. | Анхан болон мэргэшүүлэх сургалтанд хамруулсан байх | Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийн тухай, ХААБ сургалтанд хамрагдав. Сэтгүүлчид ба МАА, Байгаль орчин сэдэвт зөвлөгөөнд инженер Э.Сарантуяа МААЦУ-н салбарын ажиглалт судалгаа сэдвээр илтгэл тавьж оролцсон.<br>Өвөл, хаврын улирал угтсан цахим, зөвлөмж, Шинэчлэгдсэн ажил дүгнэх журамаар бүх салбарт цахим сургалт зохион байгуулан ажилласан. Монгол улсад Ус Цаг Уурын байгууллага үүсч хөгжсөний 100 жилийн ойг угтаж УЦУОШТ-өөс хийх ажлын төлөвлөгөөний дагуу видео цахим хичээл бэлтгэв | 100 |
| 3.11 | Байгууллагын гаднах өнгө үзэмжийг сэргээн засварлах, орчныг тохижуулах, гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх | Улсын төсөв | Холбогдох байгууллагаас зөвлөмж авч хэрэгжүүлсэн байна. | - | Хотын өнгө үзэмжийг сайжруулж, тав тухтай орчинг бүрдүүлнэ. | Үе шаттай хийгдэж байна. Гадна орчин болон гэрэлтүүлэг сайжруулсан. | 100 |
| ДӨРӨВ. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт | | | | | | | |
| 100 ЖИЛИЙН ОЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ | | | | | | | |
| 4.1 | Иргэдэд Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн үйл ажиллагааг сурталчлан таниулах ажиллагааг зохион байгуулах | Улсын төсөв | Байгууллагын талаарх мэдээлэл иргэдэд хүрсэн байна. | - | Иргэд олон нийт Ус цаг уурын байгууллагын үйл ажиллагаатай танилцсан байна | Албан хаагчид болон сум орон нутгийн байгууллага иргэдэд үйл ажиллагаа сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан. Дэлхийн цаг уур болон усны өдрийн хүрээнд Булган мээж болон Ханги сав газартай хамтран АХА тэмцээн, гар бөмбөгийн тэмцээн уралдаан зохион байгуулж ажил мэргэжилээ сурталчлав. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.2 | Хандив цуглуулж ажлын байрны тав тухтай орчинг бүрдүүлэх, ажиллах нөхцлийг сайжруулах | Улсын төсөв | Албан хаагчдын ажиллах орчин сайжирч, ажлын бүтээмж дээшилсэн байна | - | Албан хаагчдын ажиллах орчин сайжирч, ажлын бүтээмж дээшилсэн байна | Албан хаагчид болон сум орон нутгийн байгууллага, иргэдэд хандив цуглуулах үйл ажиллагаа зохион байгуулж 100 жилийн ойн арга хэмжээг аймагтаа болон УБ хотод зохион байгуулж оролцлоо. | 100 |
| 4.3 | Ус судлалын Сэлэнгэ-Хутаг харуулыг жишиг харуул болгон тохижуулах | Улсын төсөв | Ус судлалын Сэлэнгэ-Хутаг харуулыг жишиг харуул болгоход шаардлагатай бараа материалыг татсан байна. | - | Ус судлалын Сэлэнгэ-Хутаг харуул жишиг харуул болсон байна | Хөрөнгө оруулалт санхүүжилтээр материалын худалдан авалт хийгдэж тохижилтыг ажлыг хийж гүйцэтгэв. | 100 |
| 4.4 | Иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэн хариуг шуурхай өгч, төрийн ажил, үйлчилгээ хүнд суртал, чирэгдэлгүй явагдахад анхаарах. | Улсын төсөв | Шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоо<br><br>Шийдвэрлэсэн хувь | - | Өргөдөл, гомдол, хүсэлтийг 100 хувь шийдвэрлэсэн байх | Иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу хугацаанд нь шийдвэрлэж, хариу өгч байгаа бөгөөд 2024 оны жилийн байдлаар нийт 42 өргөдөл ирснийг хуулийн дагуу хугацаанд нь шийдвэрлэсэн. | 100 |
| 4.5 | МУ-ын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд ажилчин, албан хаагчид мод тарих | Улсын төсөв | тоо | 50 | 100 | Хамт олноороо дэмжин оролцож Булган сумын ЗДТГ-аас хуваарилсан газарт мод тарих ажилд идэвхтэй оролцов. Байгууллагын хашаан дотор болон эргэн тойрны 50м газрын хогийг цэвэрлэв. | 100 |
| 4.6 | Ахмад настны хөгжил оролцоог хангах арга хэмжээг хэрэгжүүлэх | Улсын төсөв | Төлөвлөгөөний биелэлт 80-аас дээш хувиар хэрэгжүүлэх | Байгууллагад 43 ахмад настан байна. | Нийт ахмад настнуудын 60-70 хувьд хүрч үйлчилгээ үзүүлсэн байна. | Цаг уурчдын баяраар байгууллагын ахмадуудыг хүлээн авч хүндэтгэл үзүүлэх, уралдаан тэмцээн зохион байгуулах болон нийт ахмадуудын гарын бэлэгт 1.900,000 мянган төгрөг зарцууллаа. Монгол улсад Ус цаг уурын байгууллага үүсэн хөгжсөний 100 жилийг ойг улсад болон аймагтаа зохион байгуулахад ахмадуудаа бүгдийг хамруулан оролцууллаа. | 100 |
| 4.7 | Улс, аймаг орон нутгийн хэмжээнд зохион байгуулж буй ажилд идэвх санаачлагатай оролцох<br>/Цэвэр орчин-Цэмцгэр Булган аян г.м/ | Улсын төсөв | Зохион байгуулсан ажлын талаарх мэдээллийг иргэдэд сурталчилсан байна. | - | Тодорхой нэг ажил санаачлан зохион байгуулна | Цэвэр орчин-Цэмцгэр Булган” аянд идэвхтэй оролцож байгууллагын хашаан дотор болон эргэн тойрны 50м газрын хогийг цэвэрлэв. | 100 |
| Нийт 4 зорилтын 45 арга хэмжээ | | | | | | | |

99,95

УЦУОШТ-Ус цаг уур орчны шинжилгээний төв
ЦУОТХ- Цаг уур орчны технологийн хэлтэс
МҮХ - Мэдээлэл үйлчилгээний хэлтэс
ЦАЗНҮА- Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаа

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

ЦУОТХ-ИЙН ДАРГА Б.БУЯННЭМЭХ
МҮХ-ИЙН ДАРГА Б.НАНДИНБАТ
АХЛАХ НЯ-БО А.ОЮУНТУЯА

2024-12-05

УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
2024 ОНЫ СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| № | Сургалтын сэдэв агуулга | Сургалтанд оролцогчид | Сургалтын хугацаа | Хүний тоо | Сургалтын хэлбэр | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Албан хаагчдын мэдлэг мэргэжил дээшлүүлэх, чадавхжуулах сургалт | УЦУОШТөвийн холбогдох албан тушаалтан | Тухай үед нь | 3 | Танхим / цахим | 2 хэлтсийн дарга хангайн бүсийн байгаль орчны салбарын албан хаагчдад уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох нап төслийн сургалтанд, Уур амьсгалын өөрчлөлтийн мал аж ахуйн салбарт үзүүлж буй нөлөөллийг зоо-цаг уурын мэдээлэлд тулгуурлан шинжлэх" сэдэвт хэлэлцүүлэгт төвийн инженер техникчид оролцов. |
| 2. | Инженер техникчдийн чадавхийг бэхжүүлэх сургалт | Инженер, техникчид | Тухайн үед | 5 | Танхим/ цахим | Уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох төлөвлөлтийн процессыг боловсронгуй болгох чадавхийг бэхжүүлэх төслийн хүрээнд Булган аймагт 2024 оны 5 дугаар сарын 16, 17-ны өдрүүдэд Уур амьсгалын өөрчлөлтийн шалтгаан, нөлөөлөл түүнд дасан зохицох үйл ажиллагааны талаар Булган аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний нийт ажилтнуудыг чадавхижуулах сургалтыг зохион байгуулав. |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| 3. | СХГ-аас эрх олгох Шалгалт тохируулгын ажилтны сургалт | УЦУОШТ-ийн багажийн инженер | 4 сард | 1 | танхим | Төвийн сургалт хийгдээгүй |
| 4. | Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны мэрэгшүүлэх сургалт | ЦАЗН үйл ажиллаганы ерөнхий инженер, техникч-жолооч | 3 сард | 2 | танхим | хийгдээгүй |
| 5. | Иргэний агаарын тээврийн нислэгт цаг агаарын урьдчилсан мэдээгээр үйлчилдэг синоптик инженерүүдэд зориулсан давтан сургалт | ЦУОШГ, НЦУТ | 4 сард | 2 | Танхим | Мэргэжил мэдлэг, ур чадварийг сайжруулах 40 цагийн давтан сургалтад 1 синоптик инженер хамрагдсан |
| 6. | Орчны хяналт шинжилгээ | БОХЗТЛ, УЦУОШТ-ийн инженер | 5 сард | 2 | танхим | БНСУ-д 7 хоног сургалтанд БОШЛ-ын инженер хамрагдсан. |
| 7. | Орон нутгийн техникч нарын чадавхыг бэхжүүлэх сургалт | Төв орон нутгийн албан хаагчид | Тухайн үед | 24 | цахим | Хаврын улиралд ажиглагддаг Аюул-агаар мэдээ, нэмэлт бүлэг, Аюул-агаар мэдээ болон синоп мэдээний уялдаа, Зэргийн шалгалтанд орох техникч зориулсан онол,зэрэг сэдвээр өртөө харуулын ажиглагч техникч нарт цахимаар сургалт оров. |
| 8. | Сорилын лабораторийн итгэмжлэл MNSISO/IEC 17025:2018 | БОШЛ-ын техникч | Тухайн үед | 1 | танхим | ҮИТ-өөс зохион байгуулагдах MNS ISO/EIC 17025:2018 сургалтанд техникчийн 2024 оны 6 сарын 13-14 хугацаанд хамруулна |
| 9. | Хэмжлийн эргэлзээ | БОШЛ-ын инженер, техникч | Тухайн үед | 2 | танхим | Хугацаа хойшлогдсон |
| 10. | Онлайн сургалт | Цаг үеийн асуудлаар | Тухайн үед | 10 | цахим | Үнэлгээ хийх нийтлэг журам төслийн танилцуулга, Грийн химистри ХХК-аас “Химийн бодисын аюулгүй ажиллагаа” БОШЛ-аас 2 /ерөнхий инженер, инженер / нар сургалтанд хамрагдсан. |
| 11. | Цаг уурын ажиглагч бэлтгэх сургалт | Өртөө харуулын техникч, ажиглагч | Жилдээ | 2 | танхим | Энэ онд хийгдээгүй. Захиалга өгсөн. |
| 12. | Шинээр ажилд орох болон дадлагын оюутны сургалт | Оюутан болон ажилд орох хүмүүс | Тухайн үед | 4 | Танхим | 2 техникч сургаж дадлагажуулсан байна. |
| 13. | Салбар нэгжүүдэд онол арга зүйн сургалт хэсэгчлэн явуулах | Салбарын инженер, техникчид | Сар бүр | 20 | Танхим / цахим | Нап төслийн сургалтанд нийт албан хаагчид хамрагдсан. 01 сарын 18 XX-26 буюу өвлийн явуул судалгааны хичээл оров. |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2024 оны 1 сарын 25 Булган станцынхантай хамт өвлийн явуул судалгааны ажиглалт хийж зааварчилга зөвлөмж өгч ажиллав. 2024 оны 03 сарын 29 нд Хутаг өртөөнд 2023 оны алдаа талаар зөвлөмж хичээл оров.<br>2024.05.17 МААЦУ, ХААЦУ-н судлагааны үр дүнгийн талаар нийт ажилчдад илтгэл тавив. |
| 14. | Үндэсний бичиг, англи хэлний мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалт хийх | Байгууллагын албан хаагчид | Жилдээ | 10 | Танхим/ цахим | Албан хаагчид сургалтанд хамрагдаж мэдлэг дээшлүүлж байна. |
| 15. | Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай ерөнхий ойлголт | Байгууллагын албан хаагчид | 3,5 сар | 15 | Танхим | 4 сард цахим сургалтанд хамрагдсан. ХХҮГ-ын мэргэжилтэн Дэлгэрмаагаас “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” сэдэвт хичээл танхим болон цахим хэлбэрээр авав. |
| 16. | Автомат станцын нэгдсэн сайт, платформ, цахим хэрэглээ | Бүх албан хаагчид | 4 сар | 15 | Танхим | Орон нутгийн албан хаагчдад мэдлэг олгох сургалт хийгдсэн. ХААЦУ-ын харуулуудад зааварчилгаа өгч зөвлөмж хүргүүлэв. |
| 17. | Хууль эрх зүйн мэдлэг олгох сургалт | Бүх албан хаагчид | Тухай үед | 20 | Танхим | 100, 98 дугаар тушаалын журмын өөрчлөлтөөр инженер техникч нарт сургалт хийв. Байгалийн баялаг хамгаалах, хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх,<br>Төрийн албан хаагчийн ёс зүй хууль эрх зүйн, талаар цахим сургалтанд хамрагдсан. |

биелэлт 88,8%

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эмнэлгээс эрүүл мэндийн онцшилгоо сургалт сурталчилгаа зохион байгуулсан. Гэр бүлийн үр бүтээлтэй цаг лекцэнд хамрагдав. Уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох, Цахим шилжилт, Орон нутгийн "Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах", "Даян дэлхийн ногоон хөгжил" буюу GGGI төслийн сургалтад оролцож мэдлэгийн хүргээгээ тэлнэ. |

биелэлт 88,8%

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

ЦУОТХ-ИЙН ДАРГА Б.БУЯННЭМЭХ

МҮХ-ИЙН ДАРГА Б.НАНДИНБАТ

АХЛАХ НЯ-БО А.ОЮУНТУЯА

БУЛГАН АЙМГИЙН УЦУОШТ-ИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАВСРАЛТ-2

## УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН АЖИЛЧДЫН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зохион байгуулах ажил | Хугацаа | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1. | УЦУОШТ-ийн контор болон сумдын цаг уурын өртөө, харуулын барилгыг сайжруулах талаар | | |
| 1.1 УЦУШ-ний Сэлэнгэ өртөө конторын барилга шинээр барих Хутаг, Могод, Тэшиг өртөөний конторын барилгыг засварлах, халаалт 00 асуудлыг шийдвэрлэх | | 2024 | Бүрэн хийгдсэн |
| 1.1 ЦУ-ын автомат станц тавигдсан харуулуудыг ажлын байртай болгох талаар сумдтай зөвшилцөх | | 2024 | Үе шаттай хийгдэж байна. |
| 1.2 Төвийн салбар нэгжийн өрөө тасалгааг хэсэгчлэн засвар үйлчилгээ хийх | | 2024 | Коридорт засвар үйлчилгээ хийгдсэн |
| 2 | Албан хаагчдын ажлын байрны талаар: | | |
| 2.1 ХААЦУ-ын Хишиг-өндөр харуулын хашаа шинэчлэх, Могод өртөөний хашаа шинэчлэх, камержуулах | | 2024 | Хишиг-Өндөр Сайхан харуул, Тэшиг, Могод өртөөний хашаа шинэчилсэн. |
| 2.2 Ус судлалын Сэлэнгэ-Хутаг харуулын багаж хадгалах байрыг засварлах болон хашаа барьж жишиг болгон тохижуулах | | 2024 | Бүрэн хийгдсэн |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| 2.3 УЦУОШТ-ийн албан хаагч бүрийг бичгийн ширээ, сандал, компьютерээр бүрэн хангах | | 2024 | Салбарын сайдын хөрөнгө оруулалт хийгдэж төв орон нутгийн салбар нэгжүүд компьютер, notebook бүрэн хангагдаж, иж бүрэн шинэчлэл хийгдсэн |
| 2.4 ЦУ-ын автомат станц тавигдсан харуулуудын ажиглагч нарыг бичгийн ширээ, сандал, компьютерээр хангах | | 2024 | Харуулын 2 ажиглагчид ширээ сандал олгож сумын ЗДТГ-с ажлын байраар хангасан. Бүх өртөө, харуул нотебок, компютерээр бүрэн хангагдсан. |
| 2.5 Ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмж, бичиг хэргийн хэрэгсэлээр хангах | | 2024 | Бүрэн хангагдсан |
| 2.6 Ажилчдын ажиллах нөхцлийн хэвийн ажиллагааг хангаж стандартын шаардлага хангасан гэрэлтүүлэг, агааржуулалт, халаалт бүхий өрөө тасалгаагаар хангах | | 2024 | Бүрэн хангагдсан |
| 3 | | | |
| 3.1 Албан хаагч өөрийн хүсэлтээр суралцах болон хүүхдээ сургахад нь хууль тогтоомжийн дагуу дэмжлэг үзүүлэх | | 2024 | Өөрийн хүсэлтээр дэмжлэг үзүүлэх боломжтой |
| 3.2 Дээд газраас зохион байгуулсан болон өөрсдийн хүсэлтээр захиалгат сургалтанд ажиллагсадыг хамруулж мэдлэг мэргэжлийг нь дээшлүүлэх | | 2024 | сургалтанд ажиллагсадыг хамруулж мэдлэг мэргэжлийг нь дээшлүүлдэг |
| 4 | | | |
| 4.1 Албан хаагчдын цалинг нэмэгдүүлэхдээ ажилласан жилийг болон ажлын үр дүнг харгалзах, цол, эрдмийн зэрэг, зэрэг дэв, мэргэшлийн зэрэг, ур чадварын болон үр дүнгийн шагналын нэмэгдлийг тогтмол хугацаанд олгох | | 2024 | Хууль тогтоомжид заасан урамшуулал, ур нэмэгдэл үр дүнгийн нэмэгдэл олгогдож байна. |
| 4.2 Ажиллагсадаас шалгалт авч мэргэшлийн зэрэг олгох | | 2024 | Бүх инженер техникч нар зэргийн шалгалтанд хамрагдсан. Шалгалтанд тэнцсэн 5 хүнд зэрэг олгогдож эхэлсэн. |
| 4.3 Албан хаагчдыг төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл үр дүнг үнэлэх журамын дагуу үнэлж улирал тутамд мөнгөн урамшуулал олгоно | | 2024 | Хууль журмын дагуу дүгнэж үр дүнгийн урамшуулал олгож байна. |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| 4.4 Орон сууц, хашаа байшин худалдан авах болон цалингийн зээлд Зээлийн баталгаа гаргаж өгөх | | 2024 | цалингийн зээл болон зээлийн баталгаа гаргаж өгч байна. |
| 4.5 Албан хаагчдад хоол, унааны мөнгийг сар бүр олгоно | | 2024 | Хоолны мөнгө 10000 тооцож олгож байна. |
| 5 | Албан хаагчдын амралт сувилал, эрүүл мэндийг сахин хамгаалах талаар: | | |
| 5.1 Албаны албан хаагчдыг нарийн мэргэжлийн эмч нарын урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, зардлыг байгууллага хариуцна. | | 2024 | Урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлэгт хамрагдсан |
| 5.2 "Эрүүл агаар эм", "Цасны баяр" сэдэвт идэвхитэй амралт, явган болон тойрон аялалыг зохион байгуулна | | 2024 | Аймаг орон нутгаас зохион байгуулж байгаа ажилд идэвхтэй оролцдог |
| 5.3 Спорт, биеийн тамирын арга хэмжээнд албан хаагчдыг оролцуулах ажлыг зохион байгуулна. | | 2024 | 100 жилийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд спортын арга хэмжээг зохион байгуулж тамирчид идэвхтэй сайн оролцсон. |
| 5.4 Долоо хоног 1 удаа 2 цаг спорт зааланд цаг авч ажилчдын бие бялдрыг чийрэгжүүлэх, эрүүл мэндийг сайжруулах арга хэмжээ авна. | | 2024 | Үйлдвэрчний хорооноос залны төлбөр гаргаж албан хаагчид идэвхтэй оролцдог. |

Биелэлт 100%

БИЕЛЭЛТ ГАРГАСАН

ЦУОТХ-ИЙН ДАРГА Б.БУЯННЭМЭХ

МҮХ-ИЙН ДАРГА Б.НАНДИНБАТ

АХЛАХ НЯ-БО А.ОЮУНТУЯА